

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Гомбожав	Дугаар	L142
Оршин суугаа аймаг	Сүхбаатар	Оршин суугаа сум	Асгат
Төрсөн газар		Төрсөн он	1921
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Бөөрийн сүм, Овоон сүм, Шилийн голын Бандид гэгээний хийд	Сүм хийдийн дугаар	СБДГ 005, СБАС 038
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 9-р сарын 4	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд



Сүхбаатар аймгийн Асгат сумын Бөөрийн сүм, Дарьганга сумын Овоон сүм

-Бид нэг судалгааны ажлаар явж байна. 1937, 1938 оноос өмнө Монгол нутагт үйл ажиллагаа явуулж байсан хийдүүдийг бүртгэж судалж явна? Ардчилал үүсэхийн үед 90-ээд оны үед сүм хийд байгуулахад бас учиртай байсан. Ном мэддэг хурлын дэг жаяг мэдэх ганц нэг настай улс байсан . Манай аймагийн 10 хэдэн сумдад Асгатаас бусад сумдад л сүм байгуулагдлаа. Тэгээд 18, 19 жил өнгөрөхөд настай лам нар нь бүгд өнгөрлөө. Тэдний араас гарах ламгүй болчихлоо. Овоон сүм нэртэй Алтан овооны сүмд 30-аад лам байсан. Баригдахаасаа урдаар зугтаад Өвөр Монгол руу гараад явчихсан улсууд байсан юм.Тэгээд 1945 онд ардчилал үүсээд чөлөөтэй болоход нутагтаа буцаж ирсэн. Өвөр Монголыг чөлөөлөх дээр зэрэг. Тэдний хийсэн хэрэг гэж юу байхав. Баригдах болохоороо урагшаа гараад явчихсан.Лантуугийн хийд, Авгын Сөнөдийн хийд энэ тэрд сууж байсан нутагтаа ах дүү нартаа ирээд. Тэд нар бол хөөрхий төр ч тэднийг хэрэглээгүй тэгээд л нас нөхцсөн.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Тэрнээс хойш сүм л үлдээд ер нь одоо зогсонги байдалд орсон. Хүн өнгөрлөө гэхэд 6 ерөөл, маанитай уншдаг лам байхгүй болчоод байна. Би Дарьгангаар л жишээлье л дээ. Дарьгангын Алтан овоо гэдэг бол Манжийн хааны үеийн түүхтэй. Дарьгангын хошуу гэдэг чинь хааны сүргийг хадгалж явсан эртний түүхтэй газар. Дарьгангын Алтан овоо гэдэг хошуу сүм нь байсан. Энэ Дарьгангын 6 сумын тэргүүн нь Овоон сүм байсан. Эзэнд мэдээтэй зөвшөөрөл авсан 13 сүм байсан байна. Энэ 6 сумд. Эдгээр 13 сүмийг удирдаж байсан сүм нь Овоон сүм. Хувьсгалт намын үед лам нар баригдаад явчихлаа. Сүм хийдийг баллалаа. Устгачихлаа. Манай Асгатад Бөөрийн сүм гэдэг сүм байсан. Бөөрийн сүм 200-аад ламтай. Юм болгон хурж байсан. Цам гэдэг юм байгаагүй ийм хурал байсан. Манайхнаас бол дээд талыг нь бариад явчихсан. 20-иод ламыг барьж Дорнодын хар гэрт цаазаар авсан гэсэн. Цагаан номд манайхны гавж, аранжинба нар бүгд хэлмэгдэлд орчихсон байна лээ. Ардчиллаас хойш Бөөрийн хийдийг байгуулах санаатай ганц нэг хүн байгаа ч тэрийг удирддаг, юм мэдэх хүн алга. Харин энд тэнд сүм хийд байгуулагдвал очиж буян номоо хийдэг иймэрхүү журмаар л явж байна.

Би мөн хэлмэгдээд авсан хүн. Би өөрөө ороогүй. Миний эх эцэг ноёдын угсааны хүн. Тэгээд миний эцгийн ах хоёр сайн лам Овоон хийд дээр байж байсан. Тэр хоёр баригдах болохоор урагшаа гараад явчихсан. Тэр хоёр маань намайг жаахан хүүхэд аваад урагшаа Бандид гэгээний хийдэд суусан юм. Миний тэр хоёр ах бол хоёул тэнд нас барсан. Настай улсууд. Хэрэв тэд баригдсан бол цаазаар авахуулах ял оногдох байсан юм. Ийм байсан юм аа. Би нэлээн хэдэн жил, 12 жил Шилийн голын Бандид гэгээний хийдэд сууж байгаад 1945 онд орж ирсэн юм. Бандид гэгээний хийдийг Оросууд орж ирээд устгачихлаа. Тэргүүлэгч 40 хэдэн ламыг газар дээр нь сүмийнх нь үүдэнд жагсааж байгаад шүршчихсэн. Тэгээд Бандид гэгээний хийд тарсан юм.

Манай Дарьганга, Асгат чигийн лам нар бол залуу лам нар нь наашаа бүгд ирсэн. Өвгөн нэг нь тэндээ яаж ч амьдардаг юм тэгээд л хоцорсон доо. За ийм байна. Ингэхлээр одоо сүм хийдийн судалгаа авч байгаа бол Да хүрэнээс явж байна уу та нар? Шашин номоо дэлгэрүүлэе гэж зорьж байна уу? Энэ ажлын гол зорилго? Шашин номоо дэлгэрүүлэе гэж бодож байгаа бол Шашны сургууль төгссөн хүүхдүүдээс одоо ганц нэгийг энэ эзэнгүй болоод байгаа сүм хийдэд авчирч тавьж удирдуулмаар байна гэж Чойжамц хамбад санал хэлмээр байна. Одоо хийдүүдэд Санжид монлам, санжий гүнла хоёр олигтой ч мэдэхгүй хэдэн хүүхэд л байна. Эцэг эх нь сүжигтэй байсан бол жолооч ч хамаагүй хүн тэр сүмийг удирдаж байна. Юу ч мэдэхгүй. Тэр хүн өөрөө хийдээ удирдах мэдлэг чадвар алга байна. Одоо Овоон сүмийн хамба гээд жолооч байсан хүн байна. Би өөрөө лам байсан, уул овоонд шүтлэгтэй хүн болохоороо Алтан овоонд 4 сарын 15-нд очиж мөргөдөг юм. Хоёр жил очсон. Тав, зургаахан хүүхэд одоо жаахан жижиг 1, 2-р ангийн хүүхдүүд лам болох гэж байгаа юм биз дээ. Дорнод аймгаас нэг хүн ирээд одоо энэ сүм баларлаа гээд цагаан толгой зааж өгч байгаа юм уу дэвтэр барьчихсан хүүхэд байж байсан. Ийм байж байсан. За тэгээд Дарьгангын Алтан овоо гэдэг чинь 6 сүм тахиж байсан. Их Хайрхан уул. Шүжиглэж чадвал дайн тулаанд орсон хүнийг ч авардаг. Өвчин зовлон туссан хүнийг ч авардаг. Алтан овоондоо сүжиглэж чадвал Алтан овоо бол аль нэгэн талаар ивээл өгдөг. Ингэхлээр миний тавих санал юу гэхдээр энэ Асгат сумын талаар авах гэж байгаа бол Бөөрийн хийд гэж байсан байна. Тэрэнд сууж байсан лам нараас нэг ч хүн алга. Сүм нь нүүгээд наашаа буучихсан. Одоо туурь нь л үлдсэн байна. Сүм нь

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

анхан Бөөрийн хийд дээрээ байсан. Уул баян Баяндэлгэр, Овоо сүмүүд жаахан сэргэж байгаа. Ер нь шашныг дэлгэрүүлэе гэвэл би Сүхбаатар аймгийн Асгат сумын 86 настай Гомбожав гэдэг хүн байна. Чойжамц хамбад Сүхбаатар аймгийн сүм хийдийг одоо жаахан сэргээх талаар Шашны сургууль төгсөж байгаа хүүхдүүдээс ганц нэгийг сум суманд нь хуваарилаж өгвөл сайн байна. Энэ шашин бол одоо ингээд мөхөх нь байна шүү, хоосон сүм шувууны үүр болоод дууслаа гэж Чойжамц хамбад хэлээрэй.

Манай аймагт хойд чигтээ арай дээр байсан. Уулбаян, Баяндэлгэр гээд арай шашинтай, ганц нэг настай улсууд байгаа. Тэгээд сүм хийдээ сэргээгээд. Энэ үрд талын хэдэн сүм бүр хэрэг байхгүй. Ганц ч сүм удирдах хүн байхгүй. Нэг настай хүнээ ойччихлоор би өөрийнхөөрөө жишээ авахад манай энэ хүүхдүүд Овоон сүм рүү очиход ерөөл ном унших хүн байхгүй байна шүү дээ. Сүмд нь, Алтан овоондоо залбирчихаад ирнэ үү гэхээс биш. Дарьгангын хэдэн сүм хийд бол байхгүй болдогийн даваан дээр байна. Энийг л хэлэх үү дээ. Асгат бол сүм хийд байгуулна гээд яахав. Ёстой хувьсгалжчихсан газар. Яваандаа сүжгээрээ буй болговол болгодог юм байгаа биз. Ер нь одоо би Дарьганга хүний хувьд Дарьгангын Овоон сүмийг л жаахан дэлгэрүүлмээр байна. Эндхийд хоёр лам байгаа. Нэг нь наймаа хийж байгаа гэсэн. Нэг нь дацанд хүрж байгаа гэсэн. Бусдыг нь байг гэхэд орон нутгийнх нь хүнийг явуулмаар байна гэж дамжуулж хэлээрэй.

Эрдэнэмандал хийд гэж аймгийн төв дээр нэг хийд байна. Тэрний хамба лам гэдэг чинь малын эмч хийж байсан Даваажав гэж хүн байгаа. Хурга засаж байсан. Мал тарьж байсан хүн байгаа. Тийм нэг хүн хэзээ хойно л эцэг эх нь сүжигтэй байсан юм байлгүй тэгээд лам болсон байгаа юм.